

7

ЭКСПОРТОД ЧИГЛЭСЭН ЭДИЙН ЗАСАГ БА ВАЛЮТЫН ХАНШ

Ц.Мөнхжаргал

Удиртгал

Экпортод чиглэсэн эдийн засагт валютын ханш ямар нөлөө үзүүлдэг вэ?

Экспортод чиглэсэн эдийн засгийг сонгох нь эдийн засгийн өндөр өсөлтөд хүргэх үү?

Экпортод чиглэсэн эдийн засаг нь гадагшаа чиглэсэн хөгжлийн стратегиар тодорхойлогддог бөгөөд гадаад улс орнуудтай эдийн засгийн харилцаанд валютаар оролцдог учир судлаачийн хувьд сонирхолтой сэдэв санагдсан төдийгүй, бараг судлагдаагүй мөн бодлого боловсруулах түвшинд үлэмж ач холбогдолтой юм. Ялангуяа манай орны хувьд эдгээр хувьсагчдын хамаарлын мөн чанарыг илрүүлэх нь шийдлээ хүлээж байгаа асуудал мөн болов уу.

Монгол орны хувьд экспортод чиглэсэн эдийн засгийн бодлого боловсруулахад валютын ханшны үзүүлэх нөлөөг илрүүлж, экспортын өсөлтөнд оруулах хувь нэмрийг нь үнэлэхэд чиглэгднэ. Эл зорилгыг биелүүлэхийн тулд дараах зорилтуудыг дэвшүүлнэ. Үүнд:

1. Экпортод чиглэсэн эдийн засаг ба валютын ханшны хамаарлыг онолын түвшинд загварчилан судлах,
2. Энэхүү судалгааны ажлын хүрээнд бусад судлаачдын судалсан эмпирик ажлуудыг авч үзэж нэгтгэн дүгнэх,
3. Экспортод чиглэсэн эдийн засагт валютын ханш хэрхэн нөлөөлж байгааг эконометрикийн техник ашиглан шалгаж валютын ханшны экспортын гадагшаа чиглэсэн эдийн засгийн өсөлтөд оруулах хувь нэмрийг тооцох зэрэг болно.

Олон орны хувьд Экспортод чиглэсэн эдийн засагт юу, хэрхэн нөлөөлдгийг судалсан олон арван судалгаанууд байдаг. Жишээлбэл Спраут /Sprout/ болон Бийвэр /Weaver/ - зэрэг эконометрикс шинжээчид, судалдаачдын шинэжилгээ судалгааны үр дүнд экспортын өсөлт ба эдийн засгийн өсөлтийн хоорондын хамаарал нь эерэг байна гэсэн дүгнэлт гаргасан. Эндээс нэг анхаарал татсан асуудал бол экспортын өсөлт бүтээгдэхүүний гарцын өсөлтийг хангадаг уу, эсэргээр бүтээгдэхүүний гарцын өсөлт экспортын өсөлтөд нөлөөлөх үү? гэсэн асуулт юм. Чая /Chow/ (1987) экспортын өсөлт ба аж үйлдвэрийн секторуудын хөгжлийг 1960-1970 оны хооронд хэд хэдэн орны хувьд шалгаж үзээд Бразил, Хонг-Конг, Израль, Өмнөд Солонгос, Сингапур, Тайвань зэрэг орнуудад экспортын өсөлт ба аж үйлдвэрийн секторуудын хөгжил нь 2 талт буюу аль алиндаа нөлөөлсөн хандлагатай байсан бол зөвхөн Мексикийн хувьд экспортын өсөлт нь аж үйлдвэрийн өсөлтөд нөлөөлсөн нэг талт үр дүнтэй гарсан байна. Баласса /Balassa/ (1978) экспортод чиглэсэн аж үйлдвэржилт импортыг орлуулах аж үйлдвэржилтээ бодвол эдийн засгийн өсөлтөнд эерэг нөлөө үзүүлдгийг гаргасан. Импортыг орлуулах аж үйлдвэржилтийг бодвол экспортод чиглэсэн аж үйлдвэржилтийн стратеги нь эдийн засгийн өсөлтийг сайн хангадаг гэж үзсэн. Энэхүү судлаачдын дүгнэлтээс харахад экспортод чиглэсэн эдийн засаг нь эдийн засгийн өсөлтөнд хүргэдэг гэснээс биш экспорт ба валютын ханш хамаарлыг судалсан ганц ч судалгааны ажил олж хараагүй байна. Харин тус илтгэлээр тухайн нэг улс /Монгол/-ын хувьд экспорт чиглэсэн эдийн засагт валютын ханшны үзүүлэх нөлөөг судлах бөгөөд хугацааны цувралын шинжилгээн дээр суурилан үр дүнгээ гаргахаараа онцлог болно. Нөгөөтэйгүүр илтгэлийн ажлын судалгааны хэсгийн хүрээнд Монгол улс болон Монголын экспортлогч гол улсуудын хэрэглээний үнийн индекс, валютын ханшийн 1995-2004 оны тоон мэдээн дээр суурилан хийх бөгөөд судалгааны арга зүйн үүднээс эконометрикийн шинжилгээ ашиглан үр дүнгээ гаргахаараа шинэлэг болов уу. Үүнд

1. Монгол улсын экспортлогч гол улсуудыг сонгон авч экспортод эзлэх хувь /Wit/-ийн жин, төгрөгийн гадаад валюттай харьцах бодит ханш /Real exchange rate/-ыг тооцсоны дараа тэднийг экспортын хэмжээг төгрөгийн гадаад валюттай харьцах бодит ханшаас хамааруулан регрессийн тэгшитгэл үнэлэх

2. Төгрөгийн бодит ханшийг тооцохдоо өөрийн орны гол экспортлогч орнууын валютын ханш, экспортод эзэлж байгаа хувийн жингээр нь тооцох

Түүнээс гадна өөрийн судалгааны ажилгааны үр дүнг эдгээр хандлагуудыг баримтлан хийсэн бусад судлаачдын үр дүнтэй харьцуулах болно.

Онолын судалгаа

Экспортод чиглэсэн эдийн засаг

Экспорт нь бараа бүтээгдэхүүнийг худалдан борлуулах үйл ажиллагааны нэг хэсэг болохын хувьд улс орнуудын үйлдвэрлэлийн үргэлжлэл болж байдаг. Аливаа улс орон экспортоор дамжуулан валютын орлого олдог. Экспортын орлого нь тухайн улс орон дахь гадаад валютын нийлүүлэлтийг тодорхойлдог гол хүчин зүйл юм. Экспортоос олох татвар, тарифын орлого нь төсвийн орлого /засгийн газрын сектор/ -ын нэг чухал бүрэлдэхүүн хэсэг болдог. Нөгөө талаас гадаад сектор нь макро эдийн засгийн бүх тэнцлүүдийн тусгал нь болдог бөгөөд төлбөрийн тэнцэлд тусгагдсан тэр хэмжээгээрээ бусад улс орнуудын гадаад сектор, эдийн засагт нь нөлөөлж байдаг. Ийм учраас судлаач олон улсын худалдааны болон макро эдийн засгийн онолд тулгуурлан сэдвийн онолын үндэслэлийг тайлбарлаж байна.

Гадаад худалдаа ба үндэсний эдийн засгийн чинээлэг байдал

Дэлхийн улс орнуудын хувьд орлогын түвшинг хэмжих үндсэн үзүүлэлт нь нэг хүнд ногдох ҮНБ юм. ҮНБ-ий өсөлт нь төлбөрийн тэнцэлтэй шууд холбоотой. Гадаад худалдааны тэнцлийг сайжруулснаар төлбөрийн тэнцлийг сайжруулах боломжтой. Орчин үеийн дэлхий ертөнцөд гадаад худалдаа нь улс үндэстний хүрээнээс гадуурх зах зээлийг бий болгож, улс орнуудын хооронд хязгаарлагдмал нөөц баялгийг зүй зохистой хуваарилах замаар эдийн засгийн үр ашиг олох хэрэглүүр болон ашиглагдаж байна.

Улс үндэстнүүдийн эдийн засагт гадаад худалдааны гүйцэтгэх үүргийн талаар сонгодог эдийн засагч А.Смит, Д.Рикардо нарын бүтээлүүд өнөөг хүртэл хамгийн шилдэгт тооцогдсоор байна.

Английн эдийн засагч Адам Смитийн XVIII зууны үед нээсэн олон улсын үнэмлэхүй давуу талын онолын гол үндэслэл нь "Аливаа улс орон бусад улс орнуудтай харьцуулахад хамгийн бага зардалтайгаар үйлдвэрлэдэг, үйлдвэрлэлийн хувьд үнэмлэхүй давуу талыг олсон бараа бүтээгдэхүүнээ экспортолдог ба бусад орнуудын хамгийн бага зардлаар үйлдвэрлэдэг бараа бүтээгдэхүүнийг импортолдог" гэсэн санаад тулгуурладаг.

А.Смитийн үнэмлэхүй давуу талын онолд доорх үндсэн дутагдал байдаг гэж хэлж болно:

- Хэрвээ нэг улс орон бусадтай харьцуулахад үнэмлэхүй давуу талтай бүтээгдэхүүнийг үйлдвэрлэж чадахгүй бол яах вэ гэдэгт хариулт өгч чаддаггүй.

Олон улсын худалдааны үнэмлэхүй давуу талын энэ сул талуудыг английн эдийн засагч Давид Рикардогийн нээсэн харьцангуй давуу талын онол нөхөн гүйцээдэг. Харьцангуй давуу талын онол нь "хэрвээ улс орнууд өөрийн хамгийн бага зардлаар үйлдвэрлэдэг бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн хувьд үнэмлэхүй давуу талыг эзэмшсэн эсэхээс үл хамааран худалдаа улс орон бүрт ашигтай байдаг" тухай онолын үндэслэлийг бий болгосноороо онцгой ач холбогдолтой юм.

Олон улсын худалдааны сонгодог онолуудад заасан санаануудыг иш үндэс болгон авч үзвэл, улс орнууд гадаад худалдааны үйл ажиллагаанд оролцсоноороо үндэсний үйлдвэрлэлийнхээ үнэмлэхүй ба харьцангуй давуу талуудаа ашиглан эдийн засгийн үр ашиг олох боломжтой болдог. Энэ боломжуудыг зөвхөн экспортлох үйл ажиллагаагаар дамжуулан ашиглах боломжтой юм гэсэн үндэслэлийг дэвшүүлж болох юм. Чухам үүнд "Экспортод чиглэсэн эдийн засаг"-ийн амин сүнс нь оршиж байгаа билээ.

Гадаад худалдаа ба эдийн засгийн тогтвортой байдал

Гадаад худалдаан дахь худалдах ба худалдан авах процесс харилцан шүтэлцээтэй нарийн нийлмэл зүйл юм. Английн эдийн засагч, сонгодог эдийн засгийн онолын төлөөлөгч Жон Стюарт Майл 1848 онд хожим нь "худалдааны тэнцвэрийн нөхцөл" гэж нэрлэгдэх болсон нээлтдээ энэхүү харилцах шүтэлцээг "Улс орнуудын хувьд нийт импортын хэмжээ нь түүний төлбөрийг хийхэд шаардагдах экспортын орлогоор тодорхойлогддог, эцсийн дүндээ худалдаанд оролцогч улсуудын дотоодын зах зээлийн эрэлтээс хамаардаг" гэж томъёолсон билээ. Майлын нээсэн "тэнцвэрийн нөхцөл" нь бараа бүтээгдэхүүнийг худалдах үнэ нь импортлогч улсын дотоодын зах зээлийн эрэлттэй холбоотой болохыг тогтоож, улс орнууд ямар хэмжээний импорт хийх вэ гэдэг экспортын орлогоос хамааралтай болохыг заажээ.

Гадаад худалдааны салбарт явуулж буй бодлого улс орны төлбөрийн тэнцэл, зах зээл дэх бараа таваарын эрэлт нийлүүлэлтийн тэнцвэр нь ямар байх вэ гэдгийг тодорхойлдог. Тухайн улс орон худалдааны чөлөөт /либерал/ бодлого явуулж байгаа нөхцөлд дотоодын зах зээл дэх бараа таваарын нийлүүлэлтийг нэмэгдэж, төлбөрийн тэнцэл мууддаг. Харин протекционалист /хамгаалах/ бодлого явуулж байгаа нөхцөлд бараа таваарын нийлүүлэлт багасгаж, төлбөрийн тэнцэл сайжирдаг. Экспортын орлого их байхад валютын ханш буурдаг. Харин валютын ханшны өсөлт их байхад импорт нэмэгддэг. Импортын таваарын эрэлт их байхад ханш өснө. Харин валютын ханш өсвөл экспорт нэмэгддэг. Ийм байдлаар гадаад худалдаа нь валютын ханшны өөрчлөлтөд нөлөөлж байдаг.

Энэ бүхнээс экспортын орлогын өсөлт нь улс орны гадаад төлбөрийн тэнцлийг сайжруулдаг, дотоод зах зээл дэх эрэлт нийлүүлэлтийн тэнцвэрт нөлөөлдөг гэсэн үндэслэлүүдийг дэвшүүлж болох юм.

Гадаад худалдаа ба хөгжил дэвшил

Гадаад худалдаа хөгжөөгүй улс орон өнөөдрийг хүртэл хөгжлийн хувьд хоцрогдсон хэвээр байна. Хүн төрлөхтөний бүтээж бий болгосон соёл иргэншлийн үнэт зүйлсийг зөвхөн улс орнуудын хоорондох арилжаа солилцоогоор дамжуулан олж авах боломжтой гэсэн санааг Английн эдийн засагч А.Смит 1976 онд "Улс үндэстнүүдийн баялаг" номондоо хөндөж өгүүлсэн байдаг.

Худалдаа хийснээр ямар үр дүнд хүрэх вэ гэдэгт Хекшер-Олин-Самуэльсоны теорем хариулт өгдөг. Н-О-S загварт үндэслэсэн дээрх теоремд: "олон улсын худалдаа нь түүнд оролцогч улсуудын үйлдвэрлэлийн хүчин зүйлсийн туйлын ба харьцангуй үнийг тэнцвэржихэд хүргэнэ" гэж заажээ. Эдийн засгийн хөгжлийн хувьд хоцрогдсон Монгол улс олон улсын худалдаанд илүү идэвхитэй оролцож байж тэр дундаа экспортод чиглэсэн эдийн засгийн хөгжлийн стратегийг баримталжээ тэргүүний хөгжилтэй улс орнуудын хэмжээнд дөхөж очих гэсэн санааг бид эндээс харж болох юм.

Олон улсын худалдааны онол гадаад худалдаанд илүү идэвхитэй оролцох замаар улс орнуудын хөгжил дэвшлийн ололтыг хуваалцаж, хөгжил дэвшлээ түргэтгэхэд боломжтой юм гэдгийг нотолж байна. Майлын тэнцвэрийн нөхцөлтэй холбож авч үзвэл экспортын орлого нь бусад улс орнуудын хөгжил дэвшлийг ямар хэмжээгээр импортлох вэ гэдгийг тодорхойлдог юм. Гадаад худалдаа нь улс орнуудын хооронд хөгжил дэвшлийг түгээж, түүнийг түргэтгэх үүргийг гүйцэтгэдэг. Гадаад худалдаа нь олон улсын хэмжээнд бараа таваар, үйлдвэрлэлийн хүчин зүйлс, техник технологийг дамжуулахад чухал үүрэгтэй.

Кейнсээс хойшхи үеийн олон эрдэмтэд хөгжлийн эдийн засгийн онолыг судалж бий болгоход хүч хөдөлмөрөө зарцуулсан. Орчин үеийн хөгжлийн эдийн засгийн онол хөгжиж буй орнууд эдийн засгийн хөгжлийн гурван төрлийн бодлого /дэглэм/-ыг баримтлах боломжтой гэж үздэг байна.

Үүнд:

1. Экспортыг дэмжих бодлого
2. Импортыг орлох бодлого
3. Холимог бодлого

Уг онолд зааснаар улс орнууд өөрийн эдийн засгийн хүч нөөцөө гадагш нь чиглүүлж, олон улсын хөдөлмөрийн хуваарийн давуу талыг ашиглан орлого хуримтлуулах замаар эдийн засгийн хөгжил дэвшлээ түргэтгэх бодлогыг "Экспортыг дэмжих бдлого" хэмээн томъёолдог юм байна. Харин эдийн засгийн потенциалгаа дотогш чиглүүлж, үндэсний үйлдвэрлэлээ сэргээн босгох замаар хөгжил дэвшлээ хангах бодлогыг уг онолд "импортыг орлох бодлого" гэж тодорхойлдог байна. үндэсний эдийн засгийн потенциалгаа гадагш ба дотогш гэсэн хоёр чиглэлд нэгэн зэрэг төвлөрүүлэх замаар эдийн засгийн өсөлтийг бий болгоход чиглэсэн хөгжлийн стратегийг "холимог бодлого" хэмээн нэрлэж байна.

- Олон улсын худалдааны онол нь Монгол улс эдийн засгийн хөгжлийн өнөгийн шатанд "экспортыг дэмжих бодлого"-ыг хэрэгжүүлэх шаардлагатай юм гэдгийг зааж өгч байна.

А.Смитийн үед экспортыг үйлдвэрлэлийн илүүдэл бүтээгдэхүүнээс салах арга зам гэсэн утгаар авч үзэж байв. Харин орчин үеийн хөгжлийн эдийн засгийн онол нь "экспортыг дэмжих бодлого"-ыг эдийн засгийн өсөлтийн нэг загвар болгон авч үздэг юм.

1987 онд Дэлхийн Банкны гаргасан "Хөгжлийн Илтгэлд"-д 41 хөгжиж буй орнуудыг худалдааны стратегиар нь дараах үндсэн 4 ангилалд авч үзжээ.

1. шууд гадагшаа чиглэсэн
2. шууд бус гадагшаа чиглэсэн
3. шууд бус дотогшоо чиглэсэн
4. шууд дотогшоо чиглэсэн

Дэлхийн банкны үзсэнээр гадагшаа чиглэсэн худалдааны бодлоготой улсуудын эдийн засгийн өсөлтийн хурд нь дотогшоо чиглэсэн худалдааны бодлоготой улсуудыг бодвол илүү хурдацтай байсан гэж дүгнэжээ. Экспортод чиглэсэн эдийн засгийн стратегийг тодорхойлогддог бөгөөд гадаад зах зээлийн өрсөлдөөн, тэндээс олох ашгийг онцолдог. Экспортод чиглэсэн эдийн засаг нь дараах зүйлтэй нөхцөлдөж эсвэл чиглүүлснээр эдийн засгийн хөгжлийг дэмждэг байна:

- Хөгжиж буй орнуудад өөрсдийн нөөц, харьцангуй давуу тал, экспортод өрсөлдөх чадвартай бүтээгдэхүүн үйлдвэрлэхийн тулд хөдөлмөрийг эрчимтэй ашигладаг технологийг илүү хэрэглэдэг.
- Хөдөлмөрийг эрчимтэй ашиглах технологи нь шууд ажил эрхэлтийг нэмэгдүүлдэг.
- Ажил эрхлэлтийн боломж нэмэгдсэнээр орлогын илүү тэгш хуваарилалт бий болно.

- Олон улсын өрсөлдөөнд орсноор (ховор нөөцийн илүү үр ашигтай хуваарилалт хийх) эдийн засгийн өсөлт хөгжилд сайн нөлөөтэй.
- Экспортын өсөлт нь төлбөрийн тэнцэл сайжирахад төдийгүй ҮНБ өсөхөд чухал нөлөөтэй.
- Засгийн газар ирэдүйд төсвийн орлого бүрдүүлэх шинэ эх үүсвэртэй болно.
- Үндэсний үйлдвэрлэл хөгжиж, Монгол орны гадаад улс орнуудаас эдийн засгийн талаар хараат байдал багасна. Үүний үр дүнд үндэсний аюулгүй байдлын хүрээнд тавигдаж буй зарим асуудлуудыг шийдвэрлэж чадна.

Ийм байдлаар "экспортод чиглэсэн эдийн засаг" нь дэлхийн аливаа улс үндэстнүүдийн өмнө тулгардаг нийтлэг шинжтэй гурван үндсэн асуудал болох эдийн засгийн өсөлт, тогтвортой байдал, хөгжил дэвшлийг бий болгодог ороо онцгой ач холбогдолтой юм.

Экспортод чиглэсэн эдийн засгийн асуудал нь шинэ сонгодог онол, шинэ марксист онолынхны сонирхол татсан асуудал юм. Энэ стратегийн талаар тодорхой нэг загвар байдаггүй бөгөөд шинээр аж үйлдвэржсэн орон болгон өөрийн гэсэн онцлогтой байдаг.

1. Валютын ханш

Валют нь мөнгөний шинэ хэлбэр биш, харин олон улсын худалдаа, зээлийн үйл ажиллагаа явуулах онцгой арга хэрэгслэл юм. өөрөөр хэлбэл олон улсын эдийн засгийн харилцаанд ашиглагдаж байгаа мөнгө нь валют болдог. Валют гэдэг нь Итали хэлнээс гаралтай үнэ өртөг гэсэн утгатай үг юм. Валютын ханш гэдэг нь нэг орны мөнгийг нөгөө орны мөнгөөр солих агуулгыг илэрхийлнэ. үндэсний валют бүр өөр орны мөнгөөр солигдох үнэ цэнэтэй байна. Валютын ханш нь тухайн валютын эрэлт, нийлүүлэлтээр тодорхойлогдож байдаг. Валютын ханш нь төлбөрийн тэнцлийн худалдааны тооцоо зэрэг макро эдийн засгийн гол гол үзүүлэлтүүдэд маш гүнзгий нөлөө үзүүлж байдаг учраас энэ нээлттэй эдийн засаг дахь хамгийн чухал үнийн нэг нь болж байдаг. Мөн түүнчлэн хүмүүсийн, пүүсүүдийн, засгийн газрын ирээдүйд нийт макро эдийн засаг дахь үнийн түвшин, үйлдвэрлэлийн түвшин, бодит орлого ямар байх талаар хүлээлт хийхэд үндэс суурь болж байдаг.

Ер нь ханшны өөрчлөлтийн талаар ярихдаа эдийн засагчид девальвац (devaluation), ревальвац (revaluation), депрекац (depreciation) ба априкац (apperciation) нэсэн нэр томъёог хэрэглэдэг. Валютын тогтмол ханшны системийн үед үндэсний валютын ханшийг бууруулахыг девальвац гэж хэлдэг. Ревальвац гэдэг нь валютын

тогтмол ханшны системтэй үед үндэсний валютын ханшийг өсгөхийг хэлдэг. Энэ үед гадаадын тухайн үндэстний нэг нэгж валютын төлөө илүү их үнэ төлөх болж байна гэсэн үг юм. Тэгвэл валютын хөвөгч ханшны системийн үед үндэсний валютын ханш нь буурч ирвэл депрекац, өсч байвал априкац явагдлаа гэж нэрлэдэг.

Төгрөгийн нэрлэсэн ханш

Төгрөгийн нэрлэсэн үйлчилж буй ханшийн индексийг дараах томъёогоор хэмжинэ:

$$NEER = 100 * \prod_{t=1}^n S_{it}^{*w_{it}} \quad (1)$$

S_{it} - t хугацааны эцэст нэгж төгрөгтэй харьцах гадаад худалдааны i түншийн валютын ханшийн индекс (NEER-nominal effective exchange rate) / t хугацааны эцэст нэгж төгрөгтэй харьцах i экспорлогч түншийн валютын ханшийн индекс болгон тооцно/

w_{it} - t хугацааны эцэст i түншийн Монгол улсын худалдаанд эзлэх хувийн жин / t -хугацааны эцэст i түншийн Монгол улсын экспортонд эзлэх хувийн жин болгон тооцно/

n - гадаад худалдааны түнш орны тоо /экспортлогч түнш орны тоо гэж тооцно. /

Төгрөгийн бодит ханш

Тооцоо шинжилгээнд зөвхөн төгрөгийн нэрлэсэн ханшийг авч үзэх нь учир дутагдалтай. Ийм учраас төгрөгийн ханш чухам яаж өөрчлөгдөж байгааг тогтоохын тулд бид гадаад улс орнуудын инфляци болон валютын ханшийг харгалзан үздэг төгрөгийн бодит ханшийг тодорхойлох шаардлагатай юм. Бодит ханш нь Монгол улсын гадаадад өрсөлдөх чадварыг нэг индикатороор бүрэн илэрхийлж чадах үзүүлэлт юм. Төгрөгийн нэрлэсэн ханш огт өөрчлөгдөөгүй байсан ч Монголын бүтээгдэхүүний харьцангуй өрсөлдөх чадвар нь худалдааны түнш орнуудын үнийн хэлбэлзлээс болж өөрчлөгдөж байдаг. Нэрлэсэн ханшийг үнийн энэ хэлбэлзлээр тохируулсан ханш нь бодит ханш юм.

Төгрөгийн нэрлэсэн үйлчилж буй ханшийн индексийг дараах томъёогоор хэмжинэ:

$$REER = 100 * \prod_{t=1}^n \left(\frac{S_{it}^*}{P_{it}^*} \right)^{w_{it}} \quad (2)$$

S_{it}^* - t хугацааны эцэст нэгж төгрөгтэй харьцах гадаад худалдааны i түншийн валютын ханшийн индекс (NEER-nominal effective exchange rate) / t хугацааны эцэст нэгж төгрөгтэй харьцах i экспорлогч түншийн валютын ханшийн индекс болгон тооцно/

P_{it}^* - t хугацааны худалдааны i түншийн хэрэглээний үнийн индексийг Монголын үнийн индекст харьцуулсан харьцаа (REER – real effective exchange rate)

w_{it} - t -хугацааны эцэст i түншийн Монгол улсын худалдаанд эзлэх хувийн жин / t -хугацааны эцэст i түншийн Монгол улсын экспортод эзлэх хувийн жин болгон тооцно/

n - гадаад худалдааны түнш орны тоо /экспортлогч түнш орны тоо гэж тооцно. /

Төгрөгийн бодит ханш чангарч байгааг юугаар тайлбарлах вэ?
Төгрөгийн нэрлэсэн ханш тогтмол үед бодит ханш өсч байгаа зөвхөн харьцангуй үнийн бууралтаар тайлбарлаж болохоор байна:

$$REER \uparrow = \frac{NEER(average)}{CPI_{relative} \downarrow}$$

2. Онолын загвар

Экспортод чиглэсэн эдийн засгийн онолын загварыг сонгохдоо эхлээд экспортод нөлөөлөх хүчин зүйлсийг онолын хүрээнд судлан гаргаж тавих нь чухал юм. Үүнд:

Экспортын хэмжээнд нөлөөдөг хүчин зүйлсийг доорх хүснэгтэнд үзүүлье.

Хүчин зүйлүүдийн өөрчлөлт	Экспортод нөлөөлөх нь	Шалтгаан
(1) Валютын бодит ханш өсөх нь / $REER \uparrow$ /	Бууруулна	Валютын бодит ханш өссөнөөс дотоодын бараа гадаадын хувьд үнэтэй болж ирнэ.
(2) Гадаадын орлого болон үйлдвэрлэл өсөх нь / $Y^e \uparrow$ /	өсгөнө	Гадаадын орлого өссөнөөр, тэдний импортын эрэлт өснө. Дотоодын эдийн засгийн экспорт өснө.
(3) Хүмүүсийн таашаал нэмэгдэх нь	өсгөнө	Манай бараа гадаадын хэрэглэгчдэд илүү таашагдах нь манай орны экспорт шууд өснө.
(4) Бусад хүчин зүйлс	Ямар арга хэрэгслэл, бодлого явуулж байгаагаас хамаарна	Тарифын болон тарифын бус арга хэрэгслэлүүд, гадаадын ЗГ-ын бодлого гэх мэт

Тэгвэл экспортын функц нь:

$$\text{export} = f(\text{reer}, Y^e, \dots) \quad (3)$$

болно.

export - Экспортын хэмжээ

reer - Төгрөгийн бодит үйлчилч буй ханш

Y^e - Экспортлогч түнш орнуудыг үндэсний орлого

(3) тэгшитгэлээс онолын загварыг сонгохдоо дараах хүчин зүйлсийг тогтмол гэж үзье:

1. Гадаадын орлого үйлдвэрлэлийн хэмжээ өсөх нь манай экспортод нөлөөлөхгүй
2. Гадаадын хүмүүсийн манай бараа бүтээгдэхүүнээс авах таашаал өөрчлөгдөхгүй
3. Экспортлогч түнш орны За сгийн газраас тарифын болон тарифын бус арга хэрэгслэлүүд авч хэрэгжүүлдэггүй

Иймээс нөхцөл тависан экспортын функц:

$$\text{exp ort} = f(\text{reer}) \quad (4)$$

болно.

Эндээс бидний онолын загвар:

$$\text{exp ort}_i = \alpha + \beta * \text{reer}_i \quad (5)$$

α - параметр /Төгрөгийн үйлчилж буй ханшнаас үл хамаарах экспортын хэмжээ/

β - параметр /Төгрөгийн ханш нэг нэгжээр өөрчлөгдөхөд экспортын хэмжээ хэдээр өөрчлөгдөхийг харуулна/

Ханшны суваг нөлөөлөх нь:

Мөнгөний бодлого гадаад валютын ханшаар дамжин эдийн засагт нөлөөлдөг. Дотоод хүүний түвшин унахад үндэсний валютын хадгаламж гадаад валютын хадгаламжтай харьцуулахад ашиг багатай болно. Иймээс хадгаламж эзэмшигчид өөрсдийн хадгаламжаа гадаад валютад хөрвүүлэх сонирхолтой болно. Гадаад эрэлт нэмэгдэхийн хирээр гадаад валютын ханш өсч, үндэсний валютын ханш унана. Улмаар, дотоодод үйлдвэрлэгдсэн барааны үнэ өндөр ханштай гадаад валютаар худалдан авсан барааны үнээс хямд болно. Иймээс дотоодын бараа гадаад зах зээл дээр илүү өрсөлдөх чадвартай болж экспортын хэмжээ нэмэгддэг.

Валютын ханшны энэхүү сувгийг дараах схемээр товчхон үзүүлж болно:

$$M^S \Rightarrow i \downarrow \Rightarrow NX \uparrow | \text{export} \uparrow \Rightarrow Y \uparrow$$

II Эмпирик судалгаа, Экспортын тооцоо

Монгол улс жижиг нээлттэй эдийн засагтай орны хувьд гадаад худалдааг дэлхийн олон улс орнуудтай хийж байна. Монгол улсын 1995-2004 онуудад экспортын хэмжээгээрээ хамгийн их хувийн жин эзэлж буй 8 орныг энэхүү судалгаа ажилдаа оруулахаар сонгон авлаа. үүнийг доорх хүснэгтээс харч болно.

Хүснэгт 1. Экспорт, оны үнээр, сая ам.доллар

	1995	1996	1997	1998	1999	2000	2001	2002	2003	2004
Бүгд	473.3	424.3	568.5	462.3	454.2	535.8	521.5	524.0	615.9	869.7
үүнээс:										
АНУ	25.8	17.8	30.1	54.4	78.0	130.2	144.5	165.7	142.9	156.3
БНСУ	26.1	34.0	44.3	33.2	2.1	12.2	20.1	22.5	7.5	9.7
ХБНГУ	7.6	4.7	6.3	9.1	2.4	2.0	2.0	2.7	4.6	11.7
Итали	11.4	10.7	11.3	10.1	14.6	14.5	16.9	8.6	9.1	17.3
Их Британи	18.7	19.3	72.0	33.2	32.2	17.5	12.4	17.5	26.1	137.4
ОХУ	68.9	87.5	46.6	40.6	48.2	45.1	44.9	48.0	41.2	20.6
БНХАУ	77.8	81.0	101.6	110.1	208.2	274.3	238.3	220.5	287.0	413.9
Япон	46.7	35.0	37.7	12.6	10.9	8.1	15.7	6.3	8.5	33.4
Экспортод эзлэх хувийн жин	59.8	68.3	61.5	65.6	87.3	94.0	94.9	93.9	85.6	92.0

Тэхээр энэхүү 8 улстай хийсэн экспортын хэмжээ манай улсын нийт экспортын хэмжээнд эзлэх хувийн жин 1995 онд бараг 60 хувьтай байсан бол 2004 оны байдлаар 92.0 хувьтай байна. Манай орны нийт экспортод 2004 оны эцсийн байдлаар АНУ 18 хувь, Их Британи 15.8 хувь, БНХАУ 47.6 хувийг эзэлж байгаа бөгөөд эдгээр 3 улс манай орны хамгийн том экспортлогч түнш орон болж байгаа юм. Харин 1995 оноос 1996 оны манай экспортын хэмжээ 10.4 хувиар буурч харин 1997 онд 1995 онтой харьцуулахад 20.1 хувиар өссөн бол 1998, 1999 онуудад 1995 оноос 2.3 хувь, 4 хувиар ту тус буурчээ. Иймээс 1995-1999 онуудыг экспортын хэмжээ тогтворгүй хэлбэлзэл ихтэй жилүүд байсан гэж үзэхээр байна. Харин 2000-2004 оны хооронд экспорт тогтвортой байсан ба 2003, 2004 онуудад 2000 онтой харьцуулахад 14.9 хувь, 62.3 хувиар огцом өссөн дүн харагдаж байна. Энэ нь манай экспортын гол

нэрийн бүтээгдэхүүн болох зэс, алт зэргийн үнэ дэлхийн зах зээл дээр өссөнтэй шууд холбоотой болов уу.

Төгрөгийн нэрлэсэн үйлчилж буй ханш

Гадаад худалдааг олон улс орнуудтай хийж байгаагийн хувьд гадаад худалдааны түнш орнуудын инфляцийн түвшин, валютын ханш экспортын хэмжээнд үлэмж нөлөөтэй юм.

Юуны түрүүнд бид индексийн тооцоо хийж буй учир харьцуулж явах суурь үе гэж байх ёстой. Монгол Банк төгрөгийн ханшийн тооцоонд 1995 оныг суурь болгон авдаг. Иймээс цаашид хийгдэх бүх тооцоонд 1995 оныг суурь он болгон авах болно.

Төгрөгийн нэрлэсэн ханшинд экспортын хувийн жин шийдвэрлэх нөлөөг үзүүлдгийг дээр дурьдсан. Манай орны урьд хөрш болох БНХАУ 1995-2004 онуудад экспортод эзлэх хувийн жин тогтвортой өссөөр 1995 онд 16.4 хувь байсан бол 2004 онд 47.6 хувийг эзэлж байна. Мөн АНУ, Их Британи, ОХУ, Япон зэрэг улсууд ихээхэн хувийг эзэлж байгаа бөгөөд Монгол улсын экспортын гол түншүүд хэвээрээ байна.

Хүснэгт 2. Монгол улсын экспортод түнш орны эзлэх хувийн жин (W_{it}), %

Улсууд	1995	1996	1997	1998	1999	2000	2001	2002	2003	2004	10 жилийн дундаж
АНУ	5.5	4.2	5.3	11.8	17.2	24.3	27.7	31.6	23.2	18.0	16.9
БНСУ	5.5	8.0	7.8	7.2	0.5	2.3	3.9	4.3	1.2	1.1	4.2
ХБНГУ	1.6	1.1	1.1	2.0	0.5	0.4	0.4	0.5	0.7	1.3	1.0
Итали	2.4	2.5	2.0	2.2	3.2	2.7	3.2	1.6	1.5	2.0	2.3
Их Британи	4.0	4.5	12.7	7.2	7.1	3.3	2.4	3.3	4.2	15.8	6.4
ОХУ	14.6	20.6	8.2	8.8	10.6	8.4	8.6	9.2	6.7	2.4	9.8
БНХАУ	16.4	19.1	17.9	23.8	45.8	51.2	45.7	42.1	46.6	47.6	35.6
Япон	9.9	8.2	6.6	2.7	2.4	1.5	3.0	1.2	1.4	3.8	4.1
Бүгд	59.8	68.3	61.5	65.6	87.3	94.0	94.9	93.9	85.6	92.0	80.3

2004 оны байдлаар эдгээр улсууд нийлээд манай улсын экспортын бараг наймны долоо буюу 87.3 хувийг бүрдүүлж байгаа нь эдгээр улсын нэгж төгрөгтэй харьцах валютын ханш нь төгрөгийн нэрлэсэн ханшид гол нөлөөг үзүүлж байна. Авч үзэж буй хугацаанд Монгол улсын экспортын эргэлтэд ХБНГУ, Итали зэрэг орнуудын хувийн жин харьцангуй тогтвортой байсан бол ОХУ, Япон, Солонгос

зэрэг улсуудын хувийн жин буурах хандлагатай байна. БНХАУ-ын эзлэх хувийн жин 1995 оноос хойш 31.2 пунктээр нэмэгдсэн байна.

Ханшийн тооцоонд хамруулж буй эдгээр 8 улс орон нь монгол улсын экспортод 2004 оны байдлаар 92.0 хувийг үзүүлж байгаа бөгөөд 10 жилийн дунджаараа 80.3 хувь байна. Төгрөгийн нэрлэсэн ба бодит ханшийн индексийн тооцоог хялбарчлах үүднээс Монгол улсыг зөвхөн эдгээр 8 оронтой худалдаа наймаа хийдэг гэж төсөөлж болох юм. Өөрөөр хэлбэл дээрх 8 улс нийлээд манай экспортын эргэлтийг 100 хувь бүрдүүлнэ гэж үзээд хувийн жингийн дахин хуваарилалт хийвэл.

Хүснэгт 3. Хувийн жингийн дахин хуваарилалт (W_{it})

Улсууд	1995	1996	1997	1998	1999	2000	2001	2002	2003	2004
АНУ	0.09	0.06	0.09	0.18	0.19	0.26	0.31	0.34	0.27	0.22
БНСУ	0.09	0.12	0.13	0.11	0.01	0.02	0.04	0.05	0.01	0.01
ХБНГУ	0.03	0.02	0.02	0.03	0.01	0.004	0.00	0.01	0.01	0.02
Итали	0.04	0.04	0.03	0.03	0.04	0.03	0.04	0.02	0.02	0.02
Их Британи	0.07	0.07	0.21	0.11	0.08	0.03	0.03	0.04	0.05	0.19
ОХУ	0.25	0.31	0.13	0.13	0.12	0.09	0.10	0.10	0.08	0.03
БНХАУ	0.28	0.28	0.29	0.36	0.52	0.54	0.51	0.45	0.54	0.59
Япон	0.17	0.12	0.11	0.04	0.03	0.02	0.03	0.01	0.02	0.05
Бүгд	1.0	1.0	1.0	1.0	1.0	1.0	1.0	1.0	1.0	1.0

Ингэснээр, тухайбал БНХАУ-ын 2004 онд Монгол улсын экспортод 47.6 бус 59 хувь, Их Британи 15.8 бус 19 хувь болтлоо өсөх юм. Цаашид хийгдэх ханшийн тооцоог судлаач дээрх хүснэгт 3-д байгаа дахин хуваарилагдсан хувийн жингээр тооцоог хийсэн болно. Үүнд:

Хүснэгт 4. Нэгж төгрөгтэй харьцах валютын ханшийн индекс ($S^* = S_{it}/S_{i0}$), %

Улсууд	1995	1996	1997	1998	1999	2000	2001	2002	2003	2004
АНУ	100	68.3	58.2	52.5	44.2	43.2	43.0	42.1	40.5	39.2
БНСУ	100	70.7	118.4	78.4	61.1	65.2	69.9	61.7	59.2	50.0
ХБНГУ	100	69.9	68.2	58.1	56.0	62.3	62.0	53.4	42.2	40.1
Итали	100	60.5	58.9	50.8	49.2	54.1	54.0	46.5	36.8	34.3
Их Британи	100	62.4	53.8	48.5	42.2	45.3	45.7	40.5	35.3	31.5
ОХУ	100	78.3	71.7	220.9	245.0	250.0	268.6	277.8	246.0	241.5
БНХАУ	100	64.1	54.6	49.7	41.4	58.5	40.2	39.4	37.8	35.8
Япон	100	78.0	75.7	61.8	45.3	48.3	55.0	51.6	43.7	41.4

2004 оны төгрөгийн бусад валюттай (ОХУ-ын рублиас бусад) харьцах албан ханшийг суурь үе болох 1995 онтой харьцуулахад 50-аас 68.5 хүртэл пунктээр тус тус суларсан (депрекац явагдсан) нь хүснэгт 4-өөс харагдаж байна. Харин рубльтэй харьцах төгрөгийн нэрлэсэн ханш мөн хугацаанд 141.5 пунктээр чангарчээ (апrikaц явагджээ).

Хүснэгт 5-г харахад төгрөгийн нэрлэсэн үйлчилж буй ханшийн индекс 2004 онд 33.3 байгаа нь суурь үеэс 66.7 пунктээр, өнгөрсөн жилийн мөн үеэс 10.7 пунктээр тус тус суларсан байна.

Хүснэгт 5. Төгрөгийн нэрлэсэн үйлчилж буй ханшийн индекс, %

Улсууд	1995	1996	1997	1998	1999	2000	2001	2002	2003	2004
АНУ	100.0	97.7	95.4	89.1	85.3	80.5	77.0	74.7	78.3	81.3
БНСУ	100.0	96.0	102.2	97.4	99.7	99.0	98.5	97.8	99.3	99.1
ХБНГУ	100.0	99.4	99.3	98.4	99.7	99.8	99.8	99.7	99.2	98.5
Итали	100.0	98.1	98.3	97.8	97.5	98.2	97.8	98.7	98.3	97.4
Их Британи	100.0	96.9	87.9	92.4	93.3	97.3	97.9	96.8	95.0	79.9
ОХУ	100.0	92.8	95.6	111.2	111.3	108.5	110.0	110.5	107.3	102.6
БНХАУ	100.0	88.2	83.7	77.6	63.3	74.7	62.8	65.9	58.9	54.8
Япон	100.0	97.0	97.0	98.0	97.9	98.8	98.0	99.2	98.7	95.9
NEER	100	70.3	64.9	65.2	53.2	60.9	49.1	50.2	44.9	33.3

Төгрөгийн үйлчилж буй бодит ханш

Нэг талаас 1995 оныг суурь болгосон Монголын Хүй 1995-2004 оны хооронд тасаралтгүй өсч байсан нь хүснэгт 6-аас харагдаж байна. Нөгөө талаас мөн хугацаанд дотоодын хэрэглээний үнийн өсөлт (ОХУ-ын Хүй-ийг эс тооцвол) бусад орны Хүй-ээс үргэлж түрүүлж байжээ.

Харьцангуй үнэ буюу Монгол улсын Хүй-т харьцуулсан харьцаа 1995-2004 оны хооронд зөвхөн ОХУ-ын рубльтэй харьцуулсан харьцангуй үнэ өсч байсан бол бусад улстай буурч байсныг хүснэгт 6-оос харагдаж байна.

Хүснэгт 6. Экспортын түнш орны Хүй-ийг Монголын Хүй-т харьцуулсан харьцаа (P^*_{it})

Улсууд	1995	1996	1997	1998	1999	2000	2001	2002	2003	2004
АНУ	1.0	0.72	0.61	0.58	0.54	0.52	0.49	0.49	0.48	0.45
БНСУ	1.0	0.73	0.63	0.64	0.58	0.55	0.53	0.54	0.53	0.49
ХБНГУ	1.0	0.73	0.62	0.59	0.53	0.49	0.47	0.46	0.44	0.40
Итали	1.0	0.73	0.61	0.59	0.55	0.52	0.49	0.49	0.48	0.44
Их Британи	1.0	0.71	0.60	0.57	0.53	0.49	0.46	0.46	0.45	0.41
ОХУ	1.0	1.09	1.00	1.75	2.17	2.41	2.65	2.98	3.20	3.22
БНХАУ	1.0	0.77	0.69	0.65	0.58	0.55	0.50	0.50	0.52	0.46
Япон	1.0	0.68	0.57	0.53	0.48	0.44	0.39	0.38	0.36	0.33

Хүснэгт 7-аас харахад төгрөгийн бодит үйлчилж буй ханшийн индекс 2004 онд 79.4 байгаа нь суурь үеэс 20.6 пунктээр суларч, харин өнгөрсөн жилээс 1.5 пунктээр чангарсан байна. 1995-2004 оны хооронд ерөнхийдөө салрах хандлагатай байгаа төгрөгийн бодит

үйлчилж буй ханш 1997, 1998, 1999 онуудад өмнөх оноосоо чангарах хандлагатай байсан байна.

Хүснэгт 7. Төгрөгийн бодит үйлчилж буй ханш, %

Улсууд	1995	1996	1997	1998	1999	2000	2001	2002	2003	2004
АНУ	100.0	99.7	99.6	98.2	96.1	95.3	95.7	94.8	95.4	97.2
БНСУ	100.0	99.7	108.4	102.3	100.0	100.4	101.2	100.6	100.1	100.0
ХБНГУ	100.0	99.9	100.2	100.0	100.0	100.1	100.1	100.1	100.0	100.0
Итали	100.0	99.3	99.9	99.5	99.6	100.1	100.4	99.9	99.5	99.4
Их Британи	100.0	99.1	97.8	98.2	98.2	99.7	100.0	99.6	98.9	95.2
ОХУ	100.0	90.4	95.6	103.2	101.5	100.3	100.1	99.3	98.0	99.2
БНХАУ	100.0	95.0	93.5	90.9	83.7	103.7	89.1	89.5	84.4	86.3
Япон	100.0	101.6	103.1	100.7	99.9	100.2	101.1	100.4	100.3	101.0
REER	100	85.4	97.4	92.6	79.8	99.7	87.8	84.8	77.9	79.4

Загварын үнэлгээ

Одоо 1.3 бүлэгт гаргаж авсан онолын загвараа үнэлэх болно.

$$\exp ort_t = \alpha + \beta * reer_t$$

Энэхүү загвараа үнэлэхэд хэрэглэгдэх data-г доорх хүснэгтэд харуулав.

аар Жил	EX Экспортын хэмжээ, оны үнээр сая.төг	NEER Төгрөгийн үйлчилж буй нэрлэсэн ханш	REER Төгрөгийн үйлчилж буй бодит ханш	REX Бодит экспортын хэмжээ	CPI Хүй, 1995-100
1995	224098.1	100.0	100.0	224098.08	1.00
1996	293938.1	70.3	85.4	203310.63	1.45
1997	461593.6	64.9	97.4	264938.23	1.74
1998	412306.9	65.2	92.6	223262.76	1.85
1999	486189.3	53.2	79.8	239411.01	2.03
2000	587772.6	60.9	99.7	267701.96	2.20
2001	574320.1	49.1	87.8	242253.36	2.37
2002	588981.9	50.2	84.8	244206.95	2.41
2003	720787.8	44.9	77.9	285449.94	2.53
2004	1053876.4	33.3	79.4	376056.56	2.80

Загварыг үнэлгээг эконометикийн техник ашиглан гаргах бөгөөд Eviews 3.1 прагматийг ашиглан үнэлэхэд үнэлгээний үр дүн:

Dependent Variable: EX				
Method: Least Squares				
Date: 05/02/06 Time: 01:44				
Sample: 1995 2004				
Included observations: 10				
EX=C(1)+C(2)*REER				
	Coefficient	Std. Error	t-Statistic	Prob.
C(1)	1886612.	717632.4	2.628940	0.0302
C(2)	-15215.52	8077.567	-2.183676	0.0464
R-squared	0.707253	Mean dependent var	540386.5	
Adjusted R-squared	0.620660	S.D. dependent var	232928.3	
S.E. of regression	205629.6	Akaike info criterion	27.48240	
Sum squared resid	3.38E+11	Schwarz criterion	27.54291	
Log likelihood	-135.4120	F-statistic	3.848234	
Durbin-Watson stat	1.896139	Prob(F-statistic)	0.026359	

Дээрх хүснэгтээс харахад үнэлгээний үр дүн сайн гарсан байна.

$$EX_t = 1886612.0 - 15215.52 * REER_t$$

t stat (2.6) (-2.1) Adjusted R² 0.62

Энэ нь статистикийн хувь коэффициентууд нь найдвартай, тэгшитгэлийн тайлбарлах хүч тийм ч муу биш үр дүнтэй гаржээ.

ДҮГНЭЛТ

Дээр хийсэн онолын болон эмпирик судалааны үр дүнд хэд хэдэн дүгнэлт хийх боломжтой болж байна. үүнд:

1. Монгол улс нээлттэй жижиг орны хувьд экспортод чиглэсэн эдийн засгийг сонгосноор эдийн засгийн өсөлт, тогтвортой байдал, хөгжил дэвшлийг бий болгох боломжтой юм.
2. 2004 оны байдлаар Монгол улсын экспортод АНУ, Их Британи болон БНХАУ-тай хийсэн худалдаа 81.4 хувь, харин арван жилийн дунджаар АНУ, БНХАУ, ОХУ-тай хийсэн худалдаа 62.4 хувийг эдгээр гурван улс эзэлж байгаа нь төгрөгийн бодит үйлчилж буй ханшийн өөрчлөлтийн үлэмж хэсгийг дээрх дөрвөн улсын валютын ханш болон үнийн хэлбэлзэл тодорхойлоход хүргэж байна. Эдгээр дөрвөн улс манай улсын экспортын хамгийн том түнш болж байна.
3. Экспорт болон төгрөгийн бодит ханшны хоорондын хамаарлыг эконометрикийн техник ашиглан шалгахад урвуу хамааралтай буюу онолын хамааралтай адилхан үр дүн гарсан.
4. $EX_t = 18866120 - 15215.52 * REER_t$ шулуун шугаман тэгшитгэлээр илэрхийлж болохоор байна. Монгол улсын валютын ханшнаас үл хамаарах экспортын хэмжээ 1886612.0 сая төгрөг байхад харин төгрөгийн үйлчилж буй валютын ханшнаас хамаарах экспортын хэмжээ 15215.52 сая төгрөг байна

Ашигласан материал

1. Damodar N.Gujarati "Basic econometrics"
2. Bary Eichengreen, Nariko Natase "Can a rapidly- growing export-oriented economy smoothly exit an exchange rate peg? Lesson for China from Japanes high-growth era" Working paper 11625, 2005
3. Н.Грегори мэнкью "Макро эдийн засаг" УБ, 1998
4. Д.Дуламсүрэн "Олон улсын валютын харилцаа" УБ, 2001
5. Д.Даваасүрэн "Хөгжлийн эдийн засаг" УБ
6. Б.Отгонтөгс, Б.Алтанцэцэг "Макро эдийн засаг" УБ, 2000
7. Б.Батнасан "Монгол улсын экспортыг дэмжих бодлого, зохицуулалт тулгамдсан асуудлууд" УБ, 2001
8. Монгол Банк "Төгрөгийн нэрлэсэн ба бодит үйлчилж буй ханш тооцох аргачлал"
9. Монголын үндэсний статистикийн газар "Монгол улс зах зээлд" статистикийн эмхтгэл УБ, 2004
10. Монгол банкны тайлан 2002, 2003, 2004
11. Монголын үндэсний статистикийн газар "Статистикийн эмхтгэл" УБ, 2004
12. World Bank Group <http://www.worldbank.org>
13. International Monetary Fund <http://www.imf.org>